

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Шинэчилсэн найруулга

Үзэл баримтлал

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн чөлөөт, хараат бус байдал
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн хариуцлага

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний мэдээлэл хайх, хүлээн авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

3.1.1. хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж нийтэд редакторласан мэдээлэл түгээдэг хэвлэл, радио, телевиз, цахим хуудсыг

Агуулга

- Хэвлэл мэдээллийн чөлөөт, хараат бус байдал
 - Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн чөлөөт, хараат бус байдал
 - Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох
 - Мэдээллийн эх сурвалжын нууцлал
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн хариуцлага, ил тод байдал, ёс зүй
 - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлийн хариуцлага
 - Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн ил тод байдал
 - Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага

4 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн чөлөөт, хараат бус байдал

4.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь төр, байгууллага, хувь хүний хуулиар тогтоосон нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх үйл ажиллагааг чөлөөтэй, хараат бусаар явуулах эрхтэй.

4.2. Төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээлэлд цензур тогтооыг хориглоно.

(3.1.9. “цензур” гэж мэдээллийг урьдчилан хянах үйл ажиллагааг)

4.3. Хуульгүйгээр хэвлэл мэдээллийн чөлөөт, хараат бус байдлыг хязгаарласан үйл ажиллагаа явуулах, хэм хэмжээ тогтоохыг хориглоно.

5 дугаар зүйл. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох

5.1. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. Зөвхөн хууль тогтоомж, эрх зүйн акт, лавлагаа, мэдээлэл нийтлэх зорилготой тогтмол хэвлэл, цахим хаягтай байж болно.

5.2. Төрийн ил тод байдал, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

7 дугаар зүйл. Мэдээллийн эх сурвалжийн нууцлал

6.1. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээлэл өгөгчийн хүсэл зоригийн дагуу мэдээллийн эрх сурвалжийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

6.2. Энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцогчоос нийтлэгдсэн болон нийтлэгдээгүй мэдээллийг хаанаас, хэрхэн олж авсан талаар болон мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг тулган шаардах, мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, шийтгэхийг хориглоно.

3.1.8. “мэдээллийн эх сурвалж” гэж мэдээлэл өгөгч, түүний нэр, хаяг, эрхэлж буй ажил, мэргэжил, гэр бүлийн байдал, уулзсан байр, хугацаа, захидал, төлбөрийн нэхэмжлэл болон бусад мэдээлэл өгөгчийн хэн болохыг нь тогтооход шууд бусаар ашиглагдах мэдээллийг;

7 дугаар зүйл. Мэдээллийн эх сурвалжийг илчлэх нөхцөл

7.1. Дараахь үндэслэлээр шүүхийн шийдвэрээр мэдээллийн эх сурвалжийг илчилнэ:

7.1.1. Тухайн мэдээлэл үнэн бодитой эсэхийг өөр аргаар шалгаж тогтоох боломжгүй болсон;

7.1.2. Хүний амь нас, эрүүл мэндэд бодитой аюул заналхийлсэн гэж үзэх үндэслэл байгаа.

7.2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч мэдээллийн эх сурвалжийг илчлүүлэх хүсэлтээ энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байгааг нотлох баримтын хамт шүүхэд гаргаж өгнө.

7.3. Хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцогч мэдээллийн эх сурвалж илчлэгдсэний улмаас энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад дурдсан үндэслэл бий болсон гэж үзсэн тохиолдолд шүүхийн шийдвэрээр мэдээллийн эх сурвалжийг хамгаалах арга хэмжээ авна.

7.4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч илчлэгдсэн мэдээллийн эх сурвалжийн талаар бусад этгээдэд мэдээлэхийг хориглоно.

10 дугаар зүйл. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлийн хариуцлага

10.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн редакци түгээсэн нийтлэл, нэвтрүүлгийнхээ хариуцлагыг хүлээнэ.

10.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг эзэмшигч түгээсэн хууль бус зар сурталчилгааны хариуцлагыг хүлээнэ.

11 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн ил тод байдал

11.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн хувь эзэмшигчийн талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд мэдээлнэ.

10.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн 5-аас дээш хувь эзэмшигчийн өмчлөлийн хувь хэмжээг олон нийтэд ил тод мэдээлнэ

3.1.7. “зар сурталчилгаа” гэж ямар нэг бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах, худалдан авах, хөлслөх, ямар нэг үйл хэрэг, санаа бодлыг дэмжүүлэх зорилгоор зар сурталчилгаа явуулагч этгээд агуулгыг нь тодорхойлон түгээж буй нийтлэл, нэвтрүүлгийг;

12 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага

12.1. Монгол улсын иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөөс хараат бус ажиллах нөхцөл болон иргэдийн мэдэх эрхийг хамгаалах, хэвлэл мэдээллийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон хангуулах, хэвлэл мэдээллийн агуулгад олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн эзэд, сэтгүүлчид, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллагыг байгуулна.

12.2. Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллагыг энэ хуулийн 8.1 дэх заалтад дурдсан гурван талын аль нэгний буюу хамтын санаачлагаар үүсгэн байгуулж, нэр, зохион байгуулалт, дүрмээ батална.

13 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулах байгууллагын бүрэн эрх

13.1. Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллага нь олон нийтэд нээлттэй ажиллаж дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. Хэвлэл мэдээллийн мэдээллийн салбарын ёс зүйн хэм хэмжээг тогтоох;

13.1.2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн талаархи гомдлыг шийдвэрлэх, хариуцагч өөрийгөө өмгөөлөх, нотлох баримтыг үнэлэхтэй холбогдсон журам баталж мөрдүүлэх;

13.1.3. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн талаарх гомдлыг хүлээн авч сахилгын арга хэмжээ авах, уулзалт эвлэрэлийн арга хэмжээ зохион байгуулах;

13.1.4. Хэвлэл мэдээллийн салбарын ажилтан, мэдээллийн эх сурвалжийн аюулгүй байдлыг хангах талаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах

13.1.5. Иргэд байгууллагаас ирсэн гомдлыг шийдвэрлэх зардлыг тусгасан хураамжийн хэмжээ болон өөрийн үйл ажиллагааны санхүүжилтийн бусад хэлбэрийг тогтоох.

14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх

14.1. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн ур чадвар, нийтлэгдсэн мэдээллийн агуулгатай холбогдуулан иргэн, байгууллага Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллагад хандан гомдол гаргасан бол уг гомдлыг шүүх, прокурор, цагдаагийн байгууллага хүлээн авч шийдвэрлэхгүй байж болно.

14.2. Хэрэв гомдол гаргагч шүүх, прокурор, цагдаагийн байгууллагад шууд гомдол гаргасан бол уг гомдлыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн өөрийн зохицуулалтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

14.3. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн ур чадвар, нийтлэгдсэн мэдээллийн агуулгатай холбогдуулан иргэн, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авсанаас хойш Хэвлэл мэдээллийн ёс зүйн байгууллага ажлын 15 (30) хоногийн дотор шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.

14 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх

14.4. Иргэний алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд хэвлэлээр гутаагдсан гэж үзэж гомдол гаргасан этгээд тухайн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хохирол учирсаныг нотлох баримтыг гомдол хүлээн авагч байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

14.5. Энэ зүйлд заасан гомдол шийдвэрлэх журам нь иргэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлахгүй

Г.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар

Монгол Улс, Улаанбаатар хот

Төрийн ордон # 359

Утас: 976-266876

<http://www.president.mn>

erdenebat@president.mn

Мэдээлэл авах зохицуулалт

- Мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг
- Мэдээлэл авах хэлбэр
- Төрийн байгууллага, албан тушаалтаны үүрэг
- Мэдээлэл авах хүсэлт гаргах
- Хүсэлтийг хянан үзэх
- Хариу өгөх
- Мэдээлэл өгөх үйл ажиллагаанд тавих хяналт
- Гомдол гаргах
- Мэдээллийн үйлчилгээний хөлс